

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-8

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдээгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 3-8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
05 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 19 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батбаяр, Б.Батцэцэг, П.Мөнхтулга,
З.Мэндсайхан, Да.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Б.Түвшин.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, А.Энхбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан боловсруулсан 1 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 1
Бүгд: 16
93.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: Тогтоолын төслийн хавсралтын 3.1 дэх хэсгийн “тавигдах шаардлага” гэснийг “тавих шаардлагыг хуулиар нарийвчлан зохицуулж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 1
Бүгд: 16
93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 23 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
11 цаг 19 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье. Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 ирж, 52 хувьтай байгаа учраас хуралдааны ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 5 сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар нэг асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Өнөөдөр хуралдаанд дараах ажлын хэсэг оролцож байна. Л.Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Б.Жавхлан Сангийн сайд, Л.Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, А.Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, О.Мягмардорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн өрийн удирдлагын, Засгийн газрын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн, та нар тэрнийг бичээгүй байна шүү. Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Энэ эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Энд нэг Нээлттэй нийгэм форумас санал ирүүлсэн юм байна лээ. Гэхдээ Нээлттэй нийгэм форумас ирүүлсэн санал нөгөө эхний хэлэлцүүлэг дээр ирэх ёстой байсан боловч энэ эцсийн хэлэлцүүлэг дээр ирсэн учраас би та бүхэнд танилцуулахаар тараачихсан байгаа. Та бүхэн тэрэнтэй танилцана биз. Уг нь яах вэ эхний хэлэлцүүлэг дээр ирсэн байсан бол зүгээр зарим гишүүд зарчмын зөрүүтэй санал гаргаад ингээд хураалгах бололцоо байсан. Эцсийн хэлэлцүүлэг

дээр бололцоогүй байна. Танилцуулгыг та бүхэн, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг би та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр манай Байнгын хороо шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 26 дугаар биш ээ, 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтад заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, танилцуулгыг та бүхэнд тараачихсан байгаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2026 онд 6 хувь, 2027, 2028 онд 6,5 хувь байх, хэрэглээний үнийн өсөлтийн түвшнийг 2026 онд 7 хувь, 2027 онд 6,4 хувь, 2028 онд 6 хувь тус тус хүргэхээр төлөвлөсөн байна.

Мөн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026, 2028 онд алдагдалгүй байхаар тооцож, ЗГ-ын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 оны 50 хувь, 2027, 2028 онд 45 хувьтай байхаар тооцсон байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын өрийн удирдлагын 2026, 2028 оны, 26 оны стратегийн, та нарт тараасан байгаа уг нь, баримт бичиг батлах тухай Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Тэгээд хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Танилцуулгатай холбогдолтой асуулт асуух гишүүн байна уу? Ганбаатар гишүүн асуултаа асууя. Танилцуулгатай холбогдуулж.

Ж.Ганбаатар: Танилцуулгатай холбоотой асууна. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хэмжээ 6, 26 онд 6, 27 онд 6,5, 28 онд 6,5 энэ худлаа. Бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ, энэ худлаа тоо. Би эхний хэлэлцүүлэг дээр нь ч хэлсэн. Тэр 5 номер, 6 номерын дарга нараас асуулт асуусан. Энэ хэрэглээний үнийн түвшин өсөлтийн түвшин энэ инфляц худлаа. Өнөөдөр 7 хувьтай байхгүй, өнөөдөр өнөөдрийн тоо байхгүй байна л даа. Өнөөдөр бол 8,3 гэж байгаа тэр бас худлаа. Аргачлалаа өөрчилсөн юм уу яасан ийсэн юм мэдэхгүй. Үгүй ээ та нар өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Тэгэхлээр би энэ тэгээд 1 асуулт асуугаад эхний, би үгээ хэлээдэхье дээ. Асуулт асуугаад эхний хэлэлцүүлэг, хоёр дахь хэлэлцүүлэг дээр хариулсан хариултуудаа сонсох учраас нэг асуулт асуугаад яах вэ. Эцсийн хэлэлцүүлэг учраас би дүгнээд нэг хэд хэдэн зүйл хэлье. Энэ чинь 3 минутаас явж байгаа юу?

Энэ эдийн засаг маш хүндэрсэн бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд ийм хүндэрсэн байхад хэдэн гэлээ, хэдэн төсөл билээ, 15 мега гэсэн билүү, юу гэлээ тэгээд ямар мөнгөөрөө яаж хийх гэж байгаа юм бэ? Тэгээд иргэдийн амьжиргаа маш суларсан, долларын ханшийг долларын нөөцийг байна шүү дээ Ганбат даргаа 5 тэрбум доллар байна гээд зарлахад өмнөх ЗГ-ын үед доллар 3300 руу орж байсан юм. Өнөөдөр 5 тэрбум болоод тэгээд зарлахад долларын ханш эсрэгээрээ өсөөд байгаа шүү дээ. Тэгээд доллар чинь олдохгүй байна, 2, 3 ханштай байна. Тэгээд эдийн засгаа ярьдаг хүн байхгүй, тэгсэн мөртөө тэрэнтэй алалцана, энэнтэй алалцана, тэр юмыг ил гаргаж тавина, энийг ил, үгүй ээ энэ чинь ядууралтайгаа алалцах хэрэгтэй байна шүү дээ. Би 16 оноос хойш л эдийн засгийн асуудлаар ийм үг хэлж байгаа юм. Уг нь өмнөх засгууд дээр эдийн засгийн хувьд нэлээн тийм дэвшилттэй зүйлүүд урагшаагаа ахидаг байсан. Зөв, бурууг нь хэлж ойлгуулдаг байсан. Үнэхээр нээрээ энэ гадаа ард иргэдийн амьжиргаа ямар байгааг мэдэж байгаа байх л гэж би найдаж байгаа, бүгдээрээ уг нь бол мэдэж байгаа болов уу гэж. Энэ, би 1 минутаа нэмээд авчихъя.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүний 1 минутыг нэмж өгье.

Ж.Ганбаатар: Энэ зүгээр нэг жишээ хэлэхэд энэ Эрээн боомт болоод Тяньжинь боомт дээр энэ тийм түгжрэл тийм зүйл байхаа больсон юм байна лээ шүү дээ. Энэ юуг илэрхийлж байгаа вэ, сайн ажиллаад тэрийг түгжрэлгүй болгочихсон юм байхгүй шүү дээ. Монгол Улсад бүтээн байгуулалт байхгүй байна, Монгол Улсын иргэд худалдан авах чадваргүй байна. Түүнээс биш нэг тэнд нэг дарга нар сайн ажиллаад, тэр контейнерууд нь яваад, түгжрэл нь арилчихсан гэсэн үг биш. Энэ эдийн засгийн асуудлаа ярих хэрэгтэй байна шүү дээ. Эдийн засгаа яах юм бэ, энэ намар юу болох юм бэ, хавар юу болох юм намар? Энэ тоо баримт дээрээ тулгуурлаад ярьдаг хүн ерөөсөө алга. Тэрийг хэрэгжүүлэх гэсэн чинь ингэлээ, энийг хэрэгжүүлэх ч гэсэн ингэлээ, энэ мөнгөө юугаар хийх гэж байгаа юм бэ? Энэ төсвийн хүрээний тэнцэл гэдэг энэ тоо худлаа.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг үнэмшилгүй байна гээд байна шүү дээ. Тэгэхдээ Дэлхийн банк, Валютын сан 6,2, 6,3 гэсэн юм байна лээ. Тэгээд та нар тооцоо судалгаа хийсэн талаараа тайлбар өгье. Ингэе Тогтвортой байдлын зөвлөл, тэгээд ЗГ-аас хэн хариулах юм бэ? Ер нь зүгээр яах вэ тайлбарлачих та нар. Энийг чинь нийгэм үзэж байгаа учраас тайлбар хэрэгтэй. 5 номер, тэгээд Тогтвортой байдлын зөвлөлөөс нэг нь. 5 номер хариулъя.

Л.Энх-Амгалан: Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Инфляц одоо бол 8,6 хувьтай байна. Энэ ондоо 9 гаруй хувьтай жилийн дундаж дээрээ байна гэж бид төсөөлж байгаа юм. Ирэх оны тухайд 7 хувь, тэгээд тэрнээс цаашаа 6,4 хувь, 6 хувь болж буурна гэж ингэж оруулж ирсэн. Өмнөх жил төсвийн хүрээний нэмэгдэл оруулж ирэхдээ 5 хувь, 4 хувь гэдэг төсөөлөл оруулж байсан. Тэгээд энэ төсөөллөө бага зэрэг нэмэгдүүлсэн байгаа. Шалтгаан нь одоо яг дэлхийн зах зээл дээр болж байгаа түүхий эдийн үнийн уналттай холбоотой валютын орлого буурсан. Энэтэй холбоотойгоор ханшаас үүдэлтэй инфляцын дарамт цаашдаа нэмэгдэхээр байна гээд инфляцынхаа хүлээлтийг бага зэрэг нэмэгдүүлсэн байгаа.

Цаашаа буурах хандлага нь ерөнхийдөө зорилт гэсэн агуулгатай. Тэрнээс гадна зорилтын тухайд Монголбанктай энэ зорилтын агуулга нь нийцтэй байгаа.

Энэ зорилтод яаж хүрэх вэ гэхээр илүү Засгийн газар талаасаа нийлүүлэлтийн гаралтай инфляцаа бууруулах дээр нэлээд анхаарал хандуулж байгаа юм. Нийт инфляцын 40 орчим хувь нь хүнсний инфляц байдаг юм. Хүнсний инфляц энэ хүнсний хувьсгалын хүрээнд нийлүүлэлтийн гаралтай хүнсний инфляц нэлээд буурна гэсэн ийм тооцоотой байгаа. Дээр нь валютын нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой, экспортын биет хэмжээгээ буулгахгүй байгаатай холбоотой олон ажлууд Засаг дээр хийгдэж байгаа. Энэ нөлөөний хүрээнд валютын нөөц энэ түвшиндээ хадгалагдана гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. Тэгэхээр ханш дээр нэмж дарамт орж ирэх нь бага болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа. Тэгэхээр ирэх ондоо зургаа аравны долоо, 7 хувьдаа, 6 биш 7 хувьтай байгаа ирэх оны төсөөлөл. Тэгэхээр 7 хувь орчимдоо гарчихна гэсэн ийм тооцооллын хийгээд оруулж ирсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Ямар загварчлал ашиглаад байгаа юм бэ?

Л.Энх-Амгалан: Загварын хувьд хэд хэдэн ялгаатай. Яг эдийн засгийн өсөлтийг тооцоход яг нөгөө үндэсний тооцооны системээ дагаж хийдэг. Яг эдийн засгийн үзүүлэлтүүд хоорондын хамаарлын нэг тийм бүтцийн загвар ашигладаг. Энэ загварыг Валютын сан ч ашигладаг, Дэлхийн банк ч ашигладаг, ADB ч ашигладаг. Тэрэнтэй л адилхан яг Монголынхоо эдийн засагт илүү тааруулж тохируулсан тийм бүтцийн загварууд ашиглаж байдаг.

Ц.Даваасүрэн: 4 номер хариулчих юм уу, дараа нь Ганбаатар тодруулж болно. 4 номер. Тэгэхдээ та бүгд яг өөрсдийнхөө ямар загварчлалаар, яаж тооцоод байгаагаа тайлбарлаарай.

Ж.Дэлгэрсайхан: Ганбаатар гишүүний санал дээр тодруулга өгье. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд Дэлгэрсайхан. Бидний зүгээс таамаглалыг яг Олон улсын валютын сан эд нарт ашиглаж байгаа КЭМ, DIGNAR гэх мэтийн загваруудыг ашигласан. Бид нарын таамаглалын Эдийн засгийн хөгжлийн яамнаас ялгаатай нь хүлээлтэд нэг их тийм анхаарал хандуулалгүй өнөөгийн бодит нөхцөл байдлыг харсан, тэрийгээ цаашаа үргэлжилбэл яах вэ гэдэг ийм агуулгаар таамаглалаа хийсэн. Бидний зүгээс өгсөн таамаглал дээр дотоодын нийт бүтээгдэхүүнийг энэ жилийн хувьд 5 орчим хувьтай гэж үзэж байгаа. Бусад байгууллагууд нэлээд өндөр 7-гоос дээш таамаглаад байгаа. Дараа жилүүдийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн таамаглал биднийх Эдийн засгийн хөгжлийн яам, Засгийн газрын оруулж ирснээс дунджаар 1 хувиар доогуур, инфляцын түвшнийг бид 26 онд 8,2, 27 онд 7,2, 28 онд 6,8 руу буух ийм боломжтой гэж үзсэн. Энэ дээр тооцооллын хувьд нэг зүйл нь энэ суурь оны нөлөөллийг бид хэт өндөр авсан байна гэж үзсэн. Учир нь 25 оны эдийн засгийг бид 5 хувь өссөн гэж үзэж.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Суурь оноо 15-аар авсан байсан уу?

Ж.Дэлгэржаргал: Үгүй ээ үгүй, бид яах вэ суурь он гэдэг нь 25 оноо яриад байгаа юм Даваасүрэн даргаа. Тэгэхээр 25 оныг бид бид 5 хувиар өснө гэж үзэж байгаа юм. ЗГ-ын зүгээс оруулж ирсэн төсөл дээр 7,5 гэж ярьж байгаа. Ер нь 5 хувиасилүү өсөхгүй байх гэсэн. Тэгэхээр суурь оныг бид ингээд доогуур төсөөлбөл дараа жилүүдийн төсөөлөл нэлээд арай өөр болох байсан болов уу гэсэн ийм бодолтой байгаа. Тэр ч агуулгаараа бидний эдийн засгийн өсөлтийн төсөөлөл нэлээд доогуур. Эдийн засаг хөгжлийн яам ЗГ-ын оруулж ирсэн инфляцын

төсөөлөл бас бид нарынхаас харьцангуй доогуур гараад байгаа байх. Бидний хувьд эдийн засгийн өсөлтийн төсөөлөл ЗГ-ынхаас доогуур, инфляцын төсөөлөл нь өндөр яваад байгаа юм.

Тэгэхээр гол алт, нөгөө ялгаатай байдал бол бид өнөөгийн бодит нөхцөл байдлаа харсан, ЗГ маань ирээдүйд хэрэгжүүлэх томоохон төслүүд, эдийн засаг руу орох мөнгөн дээр.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Гол нь нөгөө үндэслэлүүд. Жишээлбэл ингээд та нар инфляцын түвшин буурна гээд 27, 28 оны төсөөлөл тэглээ, яагаад буурна тэрийг л Ганбаатар гишүүн сонирхоод байна.

Ж.Ганбаатар: Ер нь бидний харж байгаа таамаглалаар олон улсын байгууллага болон бусад судалгаа, бидний загвар дээр гарсан үндсэн агуулга нүүрсний үнэтэй холбоотой энэ асуудал энэ хүндрэл бол 26 оны дунд үе хүртэл болон 26 оныг дуустал ерөнхийдөө хэвээр үргэлжлэх юм байна. Тэрнээс цаашаа харьцангуй тогтворжих юм байна гэсэн гол үндэслэл дээр суурилсан. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Хариулт хангалтгүй учраас Ганбаатар гишүүн 1 минут нэмье.

Ж.Ганбаатар: Өнөөдөр ингээд хэрэглээний үнийн индекс 8,3 хувьтай гээд 1 ширхэг жишээ хэлээч. Ямар бараа 8,3 хувьтай байгаа юм бэ? Бүгд бараг 50-аас дээш хувьтай байна шүү дээ. Үнийн өсөлт. Адаглаад дэлгүүр ордог юм байгаа биз дээ. Тэгээд худлаа яриад, тэгээд хүний хэлж байгаа үгийг тэгээд үгүйсгээд байх юм. Ер нь зүгээр хэрэглээний үнийн индекс дээр ч хэлэхэд одоо энэ эдийн засагтайгаа эвлэрээд энэ төсвийн тодотголоо хийхгүй бол тэгээд улсаа бүүр сөхрүүлэх нь байна шүү дээ. Бодит байдалтайгаа эвлэрэхгүй бол намар ёстой уучлаарай, мэдэхгүй байна, зүгээр хэлье гэвэл амнаас үг гарахад бүүр. Тэгээд л бүх юмыг нүүрсний үнэтэй холбох юм. Эдийн засгаа яаж чадахгүй, тэгээд л нэг юм ярихлаар юу гэдэг юм нүүрсний үнэ л ярих юм.

Ц.Даваасүрэн: Энэ нөгөө 60, 70 хувийг нь бүрдүүлж байгаа юм нь нүүрс юм даа. Тэгээд нүүрс нь унахаар. Ер нь зүгээр яах вэ Засгийн газрын оруулж ирж байгаа таамаглал дотор нэг зүйлийг анхаарахгүй болохгүй. Одоо яг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрсний орлого, экспортын орлого байна шүү дээ 1,3 тэрбум доллароор буурчихсан байгаа. Миний зүгээр тооцож байгаагаар байна шүү дээ үнийн уналт 50 хувь байгаа юм чинь би бол бараг 4 тэрбум доллар орчим буурна гэж бодоод байгаа юм. Танайхан болохоор 2 тэрбум доллар гэж байгаа байхгүй юу, тэгээд 2 тэрбум доллароо алтаар нөхнө гэж. Ийм богино хугацаанд алтаар нөхнө гэдэг юм бол хэцүү шүү дээ. Тийм учраас энэ Ганбаатар гишүүний хэлээд байгаа жоохон бодит байдалтайгаа та нар уялдуул гээд. Яагаад гэвэл Уул уурхайн сайд байсан хүн учраас энэ богинохон хугацаанд 20 тонн алт гаргажирээд ингээд нөхчихнө гэдэг хэцүү байх.

Ингээд асуулт асууж дууслаа. Зарчмын зөрүүтэй 1 санал байна гишүүдээ, 2/3-оор дэмжих ёстой юм. Тэгэхээр зарчмын зөрүүтэй нэг саналыг, эхлээд ингэх юм байна. Би нэг горимын, зарчмын зөрүүтэй санал хураалгана. Энийг дэмжиж байна уу гэж хураалгах юм. Тэгээд 2/3 нь дэмжих юм бол би тэр саналыг хураах юм байна, тийм биз? Ингээд найруулгын шинж чанартай 1 алдаа байгаа. Тэгээд би нөгөө чуулганы хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэг дээр хэлсэн чинь нөгөө

санал хураасны дараа хэлчихсэн юм байна лээ. Тэгээд найруулгын чанартай юм. Тэгээд энэ найруулгын чанартай алдааг засъя гэсэн ийм горимын саналыг хурааа. Худлаа юм байна, биш биш, энэ чинь нээрээ юу өөрчлөгдчихсэн юм байна. Нөгөө нэг хураах санал хураалт чинь өөрчлөгдсөн.

Би та нарыг бэлэн байдалд ороорой гэхээр дахиад уншуулна. Тэгэхээр энийг цуцалъя. Тэгээд энэ чинь өөрчлөлт орчихсон юм байна лээ. Тийм, тийм юм байна лээ. Ингээд санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье, энэ чинь нөгөө унтрах ёстой шүү дээ, унтрахгүй байна шүү дээ, минийх унтрахгүй байна шүү дээ. Дахин, техникийнхэн анхаараарай, дахиад бэлдье. Минийх жишээлбэл унтрахгүй байна. Бэлэн үү? Санал хураалтад бэлтгэе. Минийх унтрахгүй л байна даа. Унтрахгүй байна. Унтрахгүй байна, энэ чинь бүгд унтрах ёстой байхгүй юу. Энэндээ зохицуулалт хийгээгүй юм болов уу? Энийг нөгөө шинэ дэгээрээ тохируулсан юм уу, энэ танхимыг? Унтрахгүй байна гэж хэл, үгүй ээ үгүй энэ минийх унтрахгүй байна шүү дээ. Минийх унтрахгүй байгаа байхгүй юу. Унтрахгүй байгаа юм чинь хэцүү шүү дээ. 13 бол орсон байна, минийх ороогүй байна. Ж.Ганбаатар гишүүн, Ж.Ганбаатар, Батлут гишүүд, Батлут байхгүй юм байна. Дахиад уншуул гэнэ хурууныхаа хээг. Хэрэггүй ээ, байж байгаарай, бид 2 л уншуулах юм.

Зарчмын зөрүүтэй найруулгын шинж чанартай 1 саналыг хураалгахыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 2/3-оор дэмжигдэх ёстой юм. Хүрэхгүй яах вэ тэгээд хуучнаараа үлдэнэ. 16 гишүүн санал хураалтад 15, 93,8 хувиар дэмжигдлээ. Би та нарт зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. Засгийн газрын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг үндэслэн хураах санал.

1.Тогтоолын төслийн хавсралтын 3.1 дэх хэсгийн “тавигдах шаардлага” гэснийг “тавих шаардлагыг хуулиар нарийвчлан зохицуулж” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 93,8 хувиар найруулгын санал дэмжигдлээ. Санал хураалт дууслаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын өрийн удирдлагын 2026, 2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд саналаараа танилцуулах гишүүн байна уу? Баясгалан гишүүн танилцуулъя гэнэ. Баясгалан гишүүн.

11.42 цаг

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

